



## Олон улсын наадам-уралдаан “УЛААНБААТАР ДАХЬ УРЛАГИЙН АССАМБЛЕЙ”

2016 оны 11-р сарын 04-13, Улаанбаатар, [www.artweek.mn](http://www.artweek.mn)

### ОРОЛЦОХ ДҮРЭМ

“УЛААНБААТАР ДАХЬ УРЛАГИЙН АССАМБЛЕЙ” Олон улсын наадам-уралдаан нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод явагдна.

**Хаяг:** Улаанбаатар дахь Оросын шинжлэх ухаан, соёлын төвийн үзэсгэлэнгийн талбай дээр (Монгол Улс, Улаанбаатар хот, 12-р хороолол, Токиогийн гудамж, 39).

**Огноо:** 2016 оны 4-13 өдрүүд

**Нээлтийн ёслол:** 2016 оны 4-ний өдөр

**Бүртгүүлэх хугацаа:** 2016 оны 10-р сарын 26 хүртэл

Наадмын албан ёсны сайт: [www.artweek.mn](http://www.artweek.mn)

#### **Оролцогчдын насны зэрэглэл:**

Хүүхэд-өсвөрийн зэрэглэл:

- Хүүхэд бүлэг: -10 нас хүртэл

- Өсвөр бүлэг: -11-ээс 15 хүртэл

Бага зэрэглэл: -15-аас 19 хүртэл

Идэрчүүд зэрэглэл: -20-оос 25 хүртэл

Залуучууд зэрэглэл : -26-аас 35 хүртэл

#### **Уралдаан хоёр үе шаттай явагдна:**

а) хагас финал: зохион байгуулах хороо ирүлсэн арт-объект/бүтээлийг үзнэ

б) финал: шилдэг 100 бүтээлийг үзэсгэлэнд гаргаж дэлгэх

Уран зургийн уралдаан

График зургийн уралдаан

Уран барималын уралдаан

Гэрэл зургийн уралдаан

Хэрэглээ гоёл чимэглэлийн уралдаан

Сүлжмэлийн уралдаан

Хүүхэлдэйн уралдаан

Уран зохиолын уралдаан

Уран уншигчдын уралдаан

(яруу найраг, үргэжилсэн үгийн зохиол)

#### **Бүртгүүлэхэд шаардагдах баримт бичиг:** (бүртгүүлэх хугацаа: 2016 оны 10-р сарын 26 хүртэл)

“УРЛАГИЙН АССАМБЛЕЙ”-д оролцохын тулд (цахим хэлбэрээр э-мэйл: [info@artweek.mn](mailto:info@artweek.mn))-рүү дараах материалыг ирүүлнэ:

а) оролцогчийн анкет

б) шогшиго (дэлгэн тавих бүтээлийн хувьд)

в) бүтээлийг цахим хэлбэрээр ирүүлэх

г) төлбөр хийсэн баримтын хуулбар

#### **Техникийн шаардлагууд:**

1. Уралдааны бүтээлд зөвхөн нэг л арт-объект/бүтээлийг тооцно. Харин нэг оролцогчоос ирүүлэх бүтээлийн тоо хязгаарлагдахгүй.
2. Уралдаанд оролцох бүх бүтээлүүд дараах параметрт тохирсон байх ёстой:
  - а) Уран зураг, график зураг, уран баримал, хэрэглээ гоёл чимэглэлийн уралдааных:
    - биеэр оролцох бол-хамгийн том хэмжээс нь 100 см хүртэл
    - эчнээгээр оролцох бол-файл 150dpi-ээс доошгүй, 20 Мб хүртэл байна.
  - б) уран зохиолын уралдааных:
    - шүлэг-200 хүртэл мөр
    - үргэлжилсэн үгийг бүтээл-6000 тэмдэгээс дээшгүй (эсвэл хэвлэсэн 3 хуудас текст, үсэгний хэмжээ 12, хоорондын зай 1,5 байхаар)
  - в) уран уншигчдын уралдааных: - унших хугацаа (уралдааны бүтээлийг унших): 3 минут хүртэл
3. Биеэр оролцох бүтээлийг бэлтгэн бүрэлдүүлэх:
  - а) тавигдах бүтээл нь шошигоотой байна (хэмжээ -7x5 см, баруун доод өнцөгт, нүүр тал дээр):
  - б) биеэр оролцогчдын бүтээлүүд босоо хананд өлгөх зориулалтын бэхлэх дэгээтэй эсвэл объект/бүтээлийг унахаас хамгаалах тавиуртай байна

**Мастер-хичээл:** Наадмын явцын дунд оролцогч, тэдний багш, эцэг эхчүүдэд зориулан Мастер-хичээл зохион явуулна

**Шагнал:** бүх оролцогчид гэрчилгээ /диплом/ -оор шагнуулна. Гран-при шагналын эзэд Москва хотод Олон улсын Урлагийн Ассамблей /[www.artfestival.info/](http://www.artfestival.info/)-д төлөөлөн оролцох хийгээд гадаад орнуудад нээгдэх хэд хэдэн үзэсгэлэнд оролцох бололцоотой байна.

#### **Зохион байгуулах хороотой харилцах холбоо:**

Интернет дахь хаяг: [www.artweek.mn](http://www.artweek.mn), э-мэйл: [info@artweek.mn](mailto:info@artweek.mn), скайп: “Euroartweek”,

ICQ/MCN 439001943, Москва дахь утас: +7 /495/ 5068044, гар утас: +7-915-0120288, утас/факс: +7 /495/ 6407722